



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 9 сарын 7 өдөр

Дугаар 344

Улаанбаатар хот

Г

Г

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол Улсын Их Хурлын 1999 оны Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, хүн амд үзүүлэх тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор “Өрхийн эмийн сан” хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээ, дүн шинжилгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажлын удирдамжийг хоёрдугаар үнэлгээний төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үнэлгээг 2015 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (Э.Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.

САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА



081223

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны ... сарын ... өдрийн
344 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫГ ДЭЛГЭРҮҮЛЭХ “ӨРХИЙН ЭМИЙН
САН” ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСГӨЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИХ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Оюунсүрэн, Эрүүл мэнд спортын яамны Хяналт-
шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Б.Пүрэвсүрэн, Хяналт- Шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын мэргэжилтэн

Гишүүд:

Г.Базархүрэл, Хяналт- Шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын мэргэжилтэн

Н.Тунгалаг, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн
мэргэжилтэн

П.Оюунбат, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын Эмнэлгийн хэрэгслийн
хэлтсийн мэргэжилтэн

Д.Нацагдорж , Мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий
мэргэжилтэн

Д.Цэрэндавга, Мэргэжлийн салбар зөвлөлийн нарийн
бичгийн дарга

Ш. Болд, Уламжлалт анааахын мэргэжлийн салбар
зөвлөлийн гишүүн, Монос УАУ-ны сургуулийн захирал

Ч.Чимэдрагчаа , Уламжлалт анааахын мэргэжлийн салбар
зөвлөлийн гишүүн, Уламжлалт анааах шинжлэх
ухааны техник үйлдвэрлэлийн корпорацийн захирал

С.Нарантуяа, Уламжлалт анааахын мэргэжлийн
салбар зөвлөлийн гишүүн

Б.Лагшмаа, Анааахын шинжлэх ухааны үндэсний их
сургуулийн зүү төөнө заслын багш, тэнхмийн эрхлэгч
/зөвшилцсөнөөр/

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны сарын юлийн
344 дугаар тушаалын-2 дугаар
Хавсралт

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫГ ДЭЛГЭРҮҮЛЭХ "ӨРХИЙН ЭМИЙН
САН" ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСГӨЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

Улаанбаатар хот

2015.08.27

1. Үндэслэл:

Эрүүл мэндийн сайдын 2010 оны "Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай" 386 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор 2010, 2014 онд үнэлэгдэж 2015 онд дуусгавар болж байна.

2. Зорилго:

Монголын уламжлалт анагаах ухааныг дэлгэрүүлэх "Өрхийн эмийн сан" хөтөлбөрийн эмийн талаар мөрдөх хууль эрх зүйн орчин, лабораторийн хүчин чадлыг сайжруулах, олон нийтэд эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэг олгох, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэн боловсронгуй болгох үйл ажиллагааны хэрэгжилтэнд үнэлгээ хийх

3. Үйл ажиллагаа

1. Үнэлгээний ажлын хэсэг байгуулах, арга хэмжээний үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээний хуваарь гаргах, үйл ажиллагааны тайланг хүлээн авах
2. Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний зөвлөлдөх уулзалт зохион байгуулах
3. Үнэлгээний хуваарийн дагуу байгууллага, аймаг орон нутгийн Эрүүл мэндийн газар, Уламжлалт анагаах ухааны төвүүдэд очиж үйл ажиллагаатай танилцах, үнэлэх
4. Үнэлгээний тайланг гаргаж Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэх, шийдвэрийн төсөл боловсруулах

4. Хамрах хүрээ:

- Аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар
- Говь алтай, завхан, дундговь, хэнтий аймгийн Уламжлалт анагаах ухааны төв
- Эрүүл мэндийн яамны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв
- Уламжлалт анагаах ухаан, шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн корпораци

- БОЭТ, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Дүүргийн Эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг
- Өрх, сумын Эрүүл мэндийн төв

5. Хугацаа: 2015 оны 08 - 09 дүгээр сарын 15

Баримтын судалгааны болон ярилцлагын аргаар үнэлгээ хийнэ

A. Баримтын судалгаанд дараах материалыг судлана.


- Хууль (монгол улсын яамны эрх зүйн байдлын хууль, эрүүл мэндийн тухай хууль, хөдөлмөрийн хууль, боловсролын тухай, төсвийн тухай хууль)
- Улсын их хурлын тогтоол (1999 оны 46-р.)
- Тушаал (Эрүүл мэндийн сайдын 2011 оны 272 тоот, 2012 оны 23 тоот, 2013 оны 154, 381 тоот тушаалуудын хэрэгжилтэнд үнэлгээ өгнө)

B. Ярилцлагын судалгаанд:


- Нийслэлийн эрүүл мэндийн газрын уламжлалт хариуцсан мэргэжилтэн
- Сэргээн засах үндэсний төвийн захирал Б.Нарантуяа
- УАШУТҮК - ын захирал Ч.Чимэдрагчaa
- Вансэмбэрүү Монгол ТББ-ын тэргүүн Х.Батжаргал
- Орхон аймгийн бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, уламжлалтын тасгийн эрхлэгч, уламжлалтын эмч, үйлчлүүлэгч
- Говь-алтай аймгийн бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, уламжлалтын тасгийн эрхлэгч, уламжлалтын э
- мч, үйлчлүүлэгч

6. Хүрэх үр дүн:

Хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээний тайлан, санал, зөвлөмж гарч, ЭМСЯ-ны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулагдсан байна.



Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны ... сарын өдрийн
344 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт



МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫГ ДЭЛГЭРҮҮЛЭХ “ӨРХИЙН
ЭМИЙН САН” ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСГӨЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУВААРЬ

| № | Үйл ажиллагаа | 8 сар | 9 сар | | | |
|---|---|----------------------|---------------------|----------------------|-----------------------|----------------------|
| | | IV долоо хоног | I долоо хоног | II долоо хоног | III долоо хоног | IV долоо хоног |
| 1 | Ажлын хэсгийн тушаал батлах, ажлын хэсгийн нэгдсэн хурал зохион байгуулах | | | | | |
| 2 | Үнэлгээний санхүүжилт, хөдөө орон нутгийн хуваарь гаргах | | | | | |
| 3 | Нэгдсэн үнэлгээ хийх аргачлал гаргах, үнэлгээ хийх | | | | | |
| 4 | Орон нутагт үнэлгээ хийх | | | | | |
| 5 | Үнэлгээний дүнг нэгтгэх | | | | | |
| 6 | ЭМСЯ-ны УЗ-ийн хуралд танилцуулах | | | | | |